



2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



Шинэ үнэт цаас болон ХК-ийн бүртгэл

2019 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн биржиг шинээр үнэт цаас бүртгүүлэхээр 3 компани хүсэлтээ ирүүлж, 4 компанийн 960.6 сая ширхэг үнэт цаасыг шинээр бүртгэж, 42.5 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.



Бүртгэлийн өөрчлөлт-Хувьцаа хуваах

“Мангал даатгал” ХК болон “Баян-Алгар” ХК-ууд нь биржиг бүртгэлтэй хувьцаагаа 1:100 харьцаагаар хуваахаар хүсэлт ирүүлснээс, “Мангал даатгал” ХК-ийн материалыг СЗХороонг хүргүүлсэн бөгөөд “Баян-Алгар” ХК-н шалгалтын ажил хийгдэж байна.



Бүртгэлтэй компанийн нэгдэл

Монголын хөрөнгийн биржиг бүртгэлтэй “Жинст Увс” ХК-г нэгдэх “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн хүсэлт СЗХороонг 2019 оны 5 дугаар сард хүлээн зөвшөөрөгдснөөр түүний 28,614,263 ширхэг үнэт цаас бүртгэгдсэн.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



Бүртгэлийн бусад өөрчлөлт

Монголын хөрөнгийн биржиг бүртгэлтэй **“Дархан гурил тэжээл” ХК** нь **нэмж үнэт цаас бүртгүүлэх** хүсэлт ирүүлсэн бөгөөд **шалгалтын ажил** хийгдэж байна.

Өрийг хувьцаагаар солих

“Шарын гол” ХК нь 2.2 тэрбум төгрөгийн **өрийг хувьцаагаар солих** хүсэлт ирүүлсэн бөгөөд одоогоор **шалгалтын ажил** хийгдэж байна.

Биржийн бүртгэлээс хасах

2019 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн биржиг бүртгэлтэй гараах **22 ХК-уудыг бүртгэлээс хассан.**

Үүнд, Баялаг налайх ХК, Алмаас ХК, Өв-Усжуулагч ХК, Харшийн гэгээ ХК, Төв Ус ХК, Ар тархи ХК, Чангмань уул ХК, Хангал ХК, Бүтээл ХК, Еврофё Азия ХК, Их үүсгэл ХК, Баялаг шарын гол ХК, Жинст ХК, Мөнх жим ХК, Их нуур ХК, Сэлэнгэ импекс ХК, Харгиа ХК, Чангмань Дундговь ХК, Сав шим ХК, Мон-асар ХК, Баянтоорой ХК, Дорнод тээвэр ХК





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Биржийн гишүүн ҮЦК



2019 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн биржид **шинээр гишүүнээр элсэхээр 2 компани** хүсэлтээ ирүүлснийг судалж байна. Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон **“Фронтиер ҮЦК” ХХК** болон **“Эм Даблью Ти Эс ҮЦК” ХХК**-уудыг биржийн **гишүүнчлэлээс хассан.**


Засгийн газрын үнэт цаас




Тайлант хугацаанд Сангийн яамнаас дотоодын зах зээлд Засгийн газрын үнэт цаас гаргахгүй байх төсөв, санхүүгийн бодлогыг баримталсантай холбоотой биржид шинээр нэмж ЗГҮЦ-ыг бүртгээгүй буюу **анхдагч зах зээлийн арилжаа огт явагдаагүй.** Харин **28.0 тэрбум төгрөгийн эргэн төлөлт** хийгдэж **280,162 ширхэг ЗГҮЦ-ыг биржийн бүртгэлээс хассан.**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Нээлттэй өгөрлөг




Орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор 2017 оноос эхлэн зах зээлийн зохицуулагч болон мэргэжлийн байгууллагууд, "Эргэнэс Тавантолгой" ХК-тай хамтран "Хөрөнгийн зах зээлийн нээлттэй өгөрлөг"-ийг зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2019 оны эхний хагас жилд **Өвөрхангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ** зэрэг аймгуудад амжилттай зохион байгуулж **нийт 7,000 гаруй иргэдэд:**

- 
- хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд,
 - хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох,
 - хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулсан байна.

Мөн **"Эргэнэс Тавантолгой" ХК-ийн** үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх гэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ.


ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛТҮҮД

Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам




Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд олон шинэ үнэт цаас амжилттай гарч, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, зах зээл игэвхжихийн хирээр зах зээлийн хөрвөх чадварыг хангах, тогтвортой байдлыг бий болгох асуудал тулгамдаж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлага үүсээг байгаа билээ. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сангуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдгээрийн нэгж эрхийг бирж бүртгэж, арилжааг зохион байгуулснаар хөрөнгө оруулагчид биржээр дамжуулан хамтын хөрөнгө оруулалтын сангуудаг хөрөнгө оруулж, оновчтой удирдлагаар хангагдах давуу талтай юм. Иймд МХБ-ээс “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын төслийг боловсруулж, МХБ-ийн ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 тоот тогтоолоор батлуулан, СЗХороогоор батламжлуулахаар хүргүүлээг байна.

НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН



ХУВЬЦААНЫ АРИЛЖАА




■ IPO

■ Хоёрдогч зах зээлийн арилжаа



ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХЖИЛТ

2019 онд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээс “Түмэн шувуут” ХК-ийн хувьд 9.1%-аар, “Ард кредит ББСБ” ХК-ийн хувьд 3 дахин их, “Монос хүнс” ХК-ийн хувьд 21%-аар, “Инвекор ББСБ” ХК-ийн хувьд 15.9%-аар тус тус давсан үзүүлэлттэй байсан нь хөрөнгийн зах зээлд сонирхогч болон оролцогчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхжсэнийг харуулж байна.





ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСУУД



ТАЙЛАНТ ХУГАЦААНД ТОП-20 ИНДЕКСИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ **20649.61** НЭГЖ БАЙНА. ТОП-20 ИНДЕКСИЙГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД **823.75** НЭГЖЭЭР БУЮУ **4.13** ХУВИАР ӨСЧ, **20785.21** НЭГЖ БОЛСОН БАЙНА.

"ТОП-20" ИНДЕКСИЙН САГСЫГ ЖИЛД НЭГ УДАА ШИНЭЧИЛДЭГ БӨГӨӨД 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ӨНГӨРСӨН ОНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР САГСЫГ ШИНЭЧЛЭХЭД ӨМНӨХ САГСАД БАГТАЖ БАЙСАН 11 КОМПАНИ ХЭВЭЭР ҮЛДЭЖ, ШИНЭЭР "ХАЙ БИ ОЙЛ" ХК, "ЖЕНКО ТУР БЮРО" ХК, "ЖИНСТ УВС" ХК, "АЙТУУЛС" ХК, "ЛЭНДМН ББСБ" ХК, "МОНГОЛ БАЗАЛТ" ХК, "ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК, "МАНДАЛ ДААТГАЛ" ХК, "АРД ДААТГАЛ" ХК -УУД НЭМЭГДЭВ.



ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад **119.7 тэрбум төгрөгөөр** буюу **4.83 хувиар** өсч, **2 их наяд 601.6 тэрбум төгрөг** болсон байна.

**2018 оны эхний
хагас**


2,481,879,441,146

**2019 оны эхний
хагас**


2,601,660,661,176

НИЙТ ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МХБ ТӨХК нь 2019 оны эхний хагас жилд үйл ажиллагаанаас нийт **994.4 сая төгрөгийн орлогыг** олж ажилласан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого **25.3%-аар**, арилжааны шимтгэлийн орлого **34.6%-аар**, хураамж үйлчилгээний хөлс **24.6%-аар** тус тус өссөн үзүүлэлттэй байна.



НИЙТ ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




МХБ ТӨХК нь 2019 оны эхний хагас жилд үйл ажиллагаанаас нийт **994.4 сая** төгрөгийн орлогыг олж, **716.9 сая** төгрөгийн заргал гаргаснаар нийт **277.4 сая төгрөгийн цэвэр орлоготой** ажилласан ба MIT цогц системийн ашиглалтын зардал болон элэгдэл, хорогдолд нийт **482.1 сая төгрөгийн зарглыг хуримтлуулж тооцсоноор** санхүүгийн тайлангаа татварын өмнөх байгалаар **204.6 сая** төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөд байна.



УЛСЫН ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь 2019 оны эхний хагас жилд Улсын төсөвт нийт **274.9 сая төгрөгийн** татвар, шимтгэлийг төлсөн нь өмнөх оны мөн үеэс **25.1%-аар өссөн** үзүүлэлт болсон байна.





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК

Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот, Монгол Улс

Факс: (976)-11-325 170

Веб хуудас: www.MSE.mn